



БОЛОВСРОЛ

Б.Насанбаяр
Ph.D /Боловсрол судлал/

EQ БА ИТГЭЛ НАЙДВАР

IX НҮҮРТ



ДеФакто **НИЙТЛЭЛ**

Д.Жаргалсайхан
Эдийн засагч, нийтлэлч

АВЛИГА - МОНГОЛЫН НИЙГМИЙН “ХОРТ ХАВДАР”

II НҮҮРТ



ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Тогтохын Чулуун
*Доктор (Ph.D.), МУИС-ийн Тогтвортой
Хөгжлийн Хүрээлэнгийн захирал*

**НЭГ НУТАГ УСНЫХАНД УЛАМЖЛАЛТ
БЭЛЧЭЭР НУТГИЙГ ЦОГЦООР НЬ
НИЙТИЙН БУЮУ ХАМТЫН
ӨМЧ ХЭЛБЭРЭЭР ЭЗЭМШҮҮЛЬЕ!**

XI НҮҮРТ



AGNUUSH
**ӨВС, МАРИХУАН, КАННАБИС..
ИНГЭЭД ЯРЬДАГ НИЙГЭМ
БОЛ ЯМАР УЧ?**

V НҮҮРТ

WEEKLY

The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ

| ЗОРИГЖУУЛНА

| МЭДЭЛЖҮҮЛНЭ

Пүрэв, 2019.08.08, №5 (109)

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ, БИЕ ДААСАН,
УЛС ТӨРИЙН НАМААС ХАРААТ БУС, ДОЛОО ХОНОГ ТУТМЫН ГЛОБАЛ СОНИН

www.jargaldefacto.com





Дамбадаржаагийн ЖАРГАЛСАЙХАН

Долоо хоног бүрийн нийтлэл,
<http://jargaldefacto.com/category/23>

АВЛИГА - МОНГОЛЫН НИЙГМИЙН “ХОРТ ХАВДАР”

Шинэ оныг би замд, Бээжинд угтаж таарав. “China Daily” сонин 2016 оны анхны дугаартаа Хятад улс авлигын хэрэгт сэжиглэгдсэн, гадаад руу дүрвэсэн оргодлуудыг хүчээр болон сайн дурын үндсэн дээр эх оронд нь авчирсан тухай мэдээлсэн нь өөрийн эрхгүй анхаарал татав.

Үндэсний хэмжээнд авлигатай тэмцэх ажлыг удирдаж буй Хятадын Коммунист намын Төв хорооны сахилга бат шалгах төв комисс “Тэнгэрийн сүлжээ” нэртэй үйл ажиллагааг олон улс даяар өрнүүлж буйг дурджээ.

Ардын дээд прокурорын тусгай ажиллагааны үр дүнд 108 хүнийг гадаадын 29 улсаас тухайн орны хууль сахиулах байгууллагуудтай хамтран ажиллаж буцаан авчирсны 70 нь сайн дураараа иржээ. Тэд нийтдээ 180 сая ам.долларын хохирол учруулсан хэрэгт сэжиглэгдэж байгаа

АВЛИГА ЯАГААД ТИЙМ АЮУЛТАЙ ГЭЖ?

Хятад улс авлигатай ийнхүү амралтгүй, тасралтгүйгээр тэмцээд буйн цаад шалтгаан юу вэ? Ерөнхийлөгч асан Жан Заминь “Авлига бол нам, төрийн бие дэх хорт хавдар, түүнийг өөгшүүлвэл манай нам, улс төрийн эрх мэдэл, социалист шинэчлэлийг нураах болно” гэж хэлж байжээ. Түүнийг залгамжлагч Ху Жинтао “Авлига бол намыг устгаж, цаашлаад улс орныг ч унагах аюултай” гэж хэлсэн нь бий. Тэд хэлж байсан, харин одоогийн Ерөнхийлөгч Си яагаад ийм хүчтэй тэмцэх болов оо.

Учир нь сүүлийн 30-аад жилд авлигын цар хүрээ, төр засгийнхны баярхсан амьдрал, тансаглал асар ихсэж, ард иргэдийн дургүйцлийг хүргэх түвшинд хүрсэн юм. Хятадууд түүхэндээ төр засагт хамгийн ухаалаг, шударга, нийгмийн

бөгөөд тэдний 31 нь гадаадад арав, долоо нь хорин жилээс дээш хугацаагаар амьдарсныг тэмдэглэсэн байна.

Бас Улсын аюулгүй байдлын яамны “Үнэгний ан-2015” үйл ажиллагааны үр дүнд оны эхний есөн сард хууль бусаар хөрөнгөжөөд зугтан дүрвэсэн 556 оргодлыг 59 орноос баривчлан авчирчээ.

Оны хамгийн сүүлчийн өдөр Байгаль хамгаалах яамны дэд сайд асан Жанг Лижунь компаниудаас хууль бусаар мөнгө завшсан, хамаатан саднаа ажилд оруулсан, албан тушаалыг нь ахиулсны төлөө бусдаас авлига авсан гэдгийг нь тогтоон баталсан, шоронд үргэлжлүүлэн хорьж, шүүхийн шийтгэл хүлээлгэх болсноо зарлав.

Төлөө сэтгэлтэй хүмүүс ажилладаг (meritocracy), тэд бүхнийг мэдэж шийдэж чаддаг гэж Күнзийн үеэс итгэж иржээ. Гэтэл одоо төр засагт буй хүмүүс тийм биш болох нь танигдахаар улс төрийн бүх системд иргэд нь итгэхээ больж, эргэлзэж эхлэж буй нь төрийн тогтолцоонд аюул учруулах юм.

Тийм ч учраас авлига нь Хятадын өнөөгийн төр засгийн оршин тогтох, эсэх асуудал аль хэдийн болчихсон, түүнийг устгаж арилгахаас өөр сонголт байхгүй гэж Ерөнхийлөгч Си Зиньпин үзэж байна. Тэр авлигыг үндсээр нь арилгахын төлөө чадах бүхнээ хийнэ, “Амьдрах, үхэх хамаагүй, миний нэр төр яах нь ч хамаагүй” гэж Улс төрийн товчооны нэгэн хурлын үеэр хэлснийг “The Diplomat” сэтгүүл эш татжээ. ►►

▶ *Ерөнхийлөгч Си-ийн эхлүүлсэн авлигын эсрэг тэмцэл өнөөдөр хоёр дахь шатандаа орж байгаа аж.*

Эхний шатанд хүчний бүх байгууллагыг захирч байсан Жу Юнканг, Хятадын Чөлөөлөх армийн ханган нийлүүлэлтийг хариуцаж байсан Зю Чайху зэрэг авлигын “баруудыг” баривчилж, хуулийн хариуцлага хүлээлгэв. “Барын зулзага”, “ялаа”-нуудыг ч олноор нь баривчилжээ. Авлигачидтай хариуцлага тооцож эхэлснээр төрийн ажилтнууд авлигад өртөхөөс айдаг болж, ард түмэнд зөв мэдээлэл хүрч эхлэв. Төрийн ажилтнууд тансаг хэрэглээнээс зайлсхийх болжээ.

Одоо хоёр дахь, амин чухал шатандаа шилжиж эхэлсэн буюу авлигаас урьдчилан сэргийлдэг, чадварлаг байгууллыг (институц) бий болгож эхэлсэн байна. Төрийн ажилтан авлига авахыг хүссэн ч, тийм боломжийг нь үгүй хийх зорилготой гэнэ. Жишээ нь, “Авлига харсан бол зургийг нь ав” гэдэг кампанит ажил зохиож, төрийн ажилтнууд тансаглаж байгаа бол гар утсаар зургийг нь аваад, дээр дурдсан Төв комиссын цахим хуудсанд байрлуулвал, төдөлгүй тухайн ажилтан(-ууд)-ыг шалгаж албан ёсны хариуг зургийн дор өгдөг болжээ.

Харин гурав дахь үе шат нь төрийн ажилтан болгон авлигад оролцох тухай бүр боддог ч үгүй болгох зорилт тавьжээ. Улс төрийн энэ соёлыг хэвшүүлэх нь байгуулал бий болгохоос хэцүү, илүү хөдөлмөр, цаг хугацаа шаардах хэдий ч тэд хэрэгжүүлэх гэнэ.

МОНГОЛЫН АВЛИГЫН ЭСРЭГ ТЭМЦЛИЙН ҮР ДҮН

Монголд ч бас авлигатай тэмцэнэ, төрөө ухаалаг болгоно, дансаа шилэн болгоно зэрэг олон сайхан үг хэлж, санал, санаачилга дээрээс гаргадаг болсныг тэмдэглэх хэрэгтэй. Гэхдээ авлига арилахгүй л байна, арилах ч үндэсгүй юм. Учир нь монголын авлигын хамгийн гол эх булаг болох улс төрийн намуудад дээрх санал, санаачилга огтхон ч хүртээлгүй. Авлига Монгол улсад улс төрийн намаар дамжаад өөрөө байгуулал болчихоод удаж байна.

Нам гэдэг байгууллын (институц) санхүү, мөнгөний эх үүсвэрийг гишүүд нь ч бодит үнэнээр нь мэдэхгүй байлаа. Ялангуяа улс төрийн намуудын сонгуулийн зардлын эх үүсвэр бол том нууц. Учир нь төрийн албан тушаал, эрх мэдлийн гол худалдааны лангуу тэнд бий.

Авлигыг арилгахыг оролдож буй удирдлагууд өөрсдөө энэ байгууллаас гарал үүсэлтэй, авлигатай холбоотой учир намаа шинэчилж чадахгүй байгаагаас болоод Монгол улсад авлигын эсрэг тэмцэл аажмаар замхран мартагддаг болжээ. Хятад шиг ганц хоёр том “барын” тухай сүр дуулиантай хэрэг мандаж, олон мэдэгдэл гарч, заримдаа баривчилгаа, шүүх, шорон болдог ч төдөлгүй “наймаалцаад”,

өршөөгөөд, цайруулаад, эцэст нь суллагдаад өнгөрдөг.

Гуравхан жилийн өмнө Монгол улсын Ерөнхийлөгч асан Н.Энхбаярыг тусгай хүчнийхэн гэрт нь дайрч ороод хүчээр өргөөд л аваад явсан, авлигын загалмайлсан эцэг болохыг нь бүх байгууллага ам уралдан зарлаад байсан ч төдөлгүй гэнэт суллагдан, гадаадад асарч сувилуулаад, эдүгээ Шадар сайд болчих шахаад сууж байна.

Ерөнхий сайд асан С.Баяр АНУ-д олон байшин авсан талаар шуурч, зураг нь сонинд тавигдаад л байсан, Авлигатай тэмцэх газраас үнэн худлыг шалгаж, ямар нэг мэдээлэл хийгээгүй.

Бараг нам бүр, намын дарга бүр өөрийн сонин, телевизтэй учир олон түмний тархийг угаадаг туршлага, чадвартай болчихов.

“Үндэсний тойм” сэтгүүлийн 2015 оны тусгай дугаарт АТГ-ын Мөрдөн шалгах хэлтсээс яллах дүгнэлт үйлдүүлэхээр шилжүүлсэн боловч Улсын прокуророос хэрэгсэхгүй болгосон 14 хэргийг үйлдэгсдийнх нь овог нэр, учруулсан хохирлыг ▶▶

- ▶ нь заан хэвлэсэн байна. Тэд УИХ-ын гишүүд, сайд дарга нар, төрийн өндөр албан тушаалтнууд бөгөөд газар, өмч хөрөнгө завшсан байна.

Монголын улс төрийн эрх баригчид бие биенийхээ гэмт үйлдлээр харилцан барьцаалж амыг нь таглаад суучихсан авлигын томоохон хэргүүд энэ мэтээр гэмт хэрэг биш бага сага алдаа, эсвэл юу ч биш болчихдог зуршил тогтов. Хааяа нэг “барын зулзага, ялааны” хэрэг илэрч, дунд, доод түвшний зарим ганц хоёр түшмэдийг золиослож, “сор тахиж” сүржигнэхээс монголын авлигын эсрэг тэмцэл хэтэрсэнгүй.


МОНГОЛД АВЛИГЫН ЭСРЭГ ТЭМЦЭЛ ЭХЛЭЭ Ч ҮГҮЙ БАЙНА

Хятадын авлигын эсрэг тэмцлийн логикоор харвал монголд үнэндээ анхны үе шат нь ч эхлээгүй байна. Авлигыг монголын нийгмийн биед ургасан хорт хавдар гэвэл түүнийг арилгаж эмчлэхийн оронд, өнгөлөн далдлаж нууж хаасаар өдий хүрлээ. Улмаар авлигыг төрийн том албан тушаалын халдашгүй эрх гэгч бамбайн дор оруулж дархлаажуулахыг оролдож байна.

Ард түмэн ухаантай учраас авлигатай тэмцсэн дүр эсгэж буй энэ эрх баригчдын үйлдлийг янз бүрийн хэлбэрээр эсэргүүцэж байгаа ч, тухай бүрт аль нэг этгээд улс төрийн ашиг хонжоо болгон завшдаг болжээ.

Авлига бол Монгол улс ардчилал, зах зээлийн сонгосон замаараа тууштай явахад нүдэнд үл үзэгдэх хамгийн том саад нь. Авлигатай төр засаг иргэдийн хийж бүтээх, түүнийхээ хэрээр сайн сайхан амьдрах боломжийг хулгайлж байна. Бид төр засгаа авлигаас салгаж, цэвэрлэж чадахгүй бол төрийн ажилтнууд тэрбумтан болдог, бусад нь ядуурч, улмаар нийгмийн баян, ядуугийн ялгаа нь улам тэлсээр байх болно. Нийгэмд уур бухимдал үүсч, эцэстээ үймээн болж, түүнийг далимдуулан улс оронд сахилга журам сахиулах нэрээр хэн нэгэн хүн хувийн засаглалаа тогтоохыг оролдож мэднэ. Авлигыг устгахгүй бол ардчиллыг маань дарангуйлал устгах болно.

2016.01.06 ■



The Defacto Gazette

НЭГ УЛИРЛЫН ҮНЭ
30.000₮

МОНГОЛ ШУУДАН
7007-8916

НИЙТЛЭЛ



AGNUUSH

ӨВС, МАРИХУАН, КАННАБИС... ИНГЭЭД ЯРЬДАГ НИЙГЭМ БОЛ ЯМАР УУ?

Табүү сэдвийн мөрөөр ...

Би хар тамхи судалдаг. Зураг дардаг, хар тамхитай холбоотой түүхэнд хоббирдог. Вьетнамд нэг мөсчин (methamphetamine) эрийг дагаж зураг авсан "дадлага" бий. Хонг Конгийн Макдоналдс-д Героин (opioid) өөртөө тарих Австрали эрийг ч өөрийн 2 нүдээр харсан удаатай.

"Намайг дагуулаад яв, харъя!" гээд л дагачихдаг.

АСУУЛТ ЭНГИЙН- ЯАГААД?

Ихэнхдээ сэтгэцийн травма, гэр бүлийн асуудал, өөрийн хувь хүний зан төлөвшлийн нөлөө байдаг. Хар тамхины төрөл бүр өөр өөрийн өгөгдөлтэй, дотроо их олон хуваагддаг. Хятад улс мөс-ний үйлдвэрлэлээрээ дэлхийд тэргүүлдэг бол байнгын үйлчлүүлэгч нь Монгол. Колумбитай ойрхон улс кокаинд живэх бол Афганистанд 12-той хүүхдүүд героин-д донтох нь энгийн л үзэгдэл юм.

Поппи ургамлын балыг химийн урвалд оруулж гаргаж авдаг Героин гэх хар тамхи бий. Нэг удаагийн тарилтаар оргазмыг 1000 үржүүлсэнтэй тэнцэх таашаалыг тархинд задлаж өгдөг. Хэрэглэсэн хүн шууд донтдог героиныг дэлхийн хамгийн аюултай хар тамхи гэж нэрлэдэг байсан цаг саяхан.

Тэгтэл героиныг ардаа хол орхих Фентанил гэх синтетик героин гараад ирчихсэн. Саяхан Карфентанил гээд Фентанилаасаа 100 дахин илүү хүчтэй синтетик героин шинээр гараад ирлээ. Химийн, байгалийн л гэж ялгардаг үе хөгжөөд синтетик гэх цоо шинэ нэр төрлийн хар тамхитай болоод байгаа. Яагаад хүмүүс донтоод байна гэдгийг асуухтай зэрэгцэж энэ бүх үхлийн ард хэн нь мөнгөө тоолж суугаад байгааг хайж олж таслан зогсоох нэн шаардлагатай байна.

Тооцоолоод үзье л дээ. Өнөөдөр сонины гаргасан энэ мэдээ хэрэв үнэн бол Б.Баттүшигийн 70 кг героины цаана хэчнээн төгрөг яригдаж байгааг зүгээр л тооны машинаар бодоод нэг үзье. НУБ-ын гаргасан энэ судалгаагаар Герман улсад худалдаалагдсан героины 2006–2016 оны ►►

- ▶ ханшийн дундаж 1 грамм = 53 Евро. 1кг-д 1000 грамм байдаг бол Б.Баттүшиг дэд консулын хилээр давуулах гэж завдсан 70кг = 3,500,000 Евро = 10.5 тэрбум төгрөг. Нийт хар тамхинаас болсон үхлийн 61%-ийг героин эзэлдэг...

Монгол улс хар тамхичдынхаа тоог мэддэггүй. Өөрсдөө ч мэдлэггүй, нийгэмдээ ч заадаггүй.

Пий Паа! саад байх зүйлгүй — бид хар тамхичидтай нийгэмд амьдардаг. Монголд хар тамхийг төрлөөр нь ангилж ялладаггүй болохоор замбараагүй олон төрлийн хар тамхийг хольж хэрэглэдэг трэнд үүсч сүүлдээ хууль чангарсан чинь эмийн сангуудаас мэдээ алдуулагч седативууд авч хамраараа сорж, хэтрүүлэн ууж биеэ хордуулах донтогчид олширсон бас залуужсан.

Хэрэглэгчдийн судалгаа байхгүй болохоор опиоид монголд хэр тархсан байгааг таамаглах боломжгүй болчихоод байгаа юм. Миний л мэдэхийн морфинд донтсон залуустай бишгүй таарч байсан. Өнөөх героины төрлийн хар тамхи. Хээр нь ургаад байдаг өвсөө ч сэдэв болгож өрнүүлж чадаагүй байхад хүнд төрлийн

ТАЙЛБАРЛАЯ.

Каннабис буюу өвс. Монголын хээр хэд хэдэн газар ургадаг. Жил болгон улсаас устгал хийдэг ч дараа жил нь эргээд ургачихдаг зэрлэгургамал. Гадны орнуудад тусгай өрөөнд усалж ургуулсан өвсийг соорт соортоор нь ангилж худалдаанд нэвтрүүлдэг бол манайхан хээр талаас өвсөө түүж татдаг ялгаатай.

Өвсөнд каннабиноид болон тэрпэнэс гэх идэвхт бодисууд байдаг. Тэрпэнэс гэх бодисыг одоо л судлаж эхлэж байгаа бол THC болон CBD гэх каннабиноидыг маш сайн судалсан байдаг. Эдгээр бодисуудын судалгаан дээр үндэслэж өвсийг ялаас чөлөөлсөн орон нэмэгдсэн, эмчилгээний зориулалтаар ашиглах нь зүйтэй хэмээн CBD тосыг өвснөөс гарган авч мянга мянган өвчтөнүүдийг эмчилж байгаа явдал ч мөн л факт.

Ихэнх орнууд хуулиараа зөвшөөрдөггүй шалтгаан нь бусад хүнд-химийн төрлийн хар тамхинд донтох гүүр болох магадлалтай гэсэн байдаг.




химийн гаралтай хар тамхинд донтогчдын түүхийг ил гаргаж ирнэ гэдэг үлгэр биз.

ЦЕГ-ын хэвлэл мэдээллийн төвийн дарга Б.Баатархүүгээс авсан энэ ярилцлагаас мөн л бид дорвитой мэдээлэл авч чадсангүй. Нэг ийм жишигтэй, тойруулж айлгадаг. “Монголд зонхилж байгаа нь каннабис, гашиш, мөс” гэсэн хэрнээ ямар учиртай хар тамхи юм гэдгийг тайлбарлаж мэдээлэл хүргэх нь энэ сэтгүүлчийн ч, дарга ахын ч ажил биш бололтой.

Гашиш

К а н н а б и с ы н навчинд байдаг идэвхт элементүүдийг шүүж барьцалдуулж гашиш шаврыг гаргаж авдаг. Монголын зах зээлд дотоодын болон гадны гэсэн 2 төрөл байдаг. Монголдоо зулгаасан өвснөөсөө шахаж гаргасан монгол бор, эсвэл “Морок” гэж хэлэгдэх гадны үнэтэй бор. Гадны Гашиш-ийг жижиглэнгээр могой хэмээж зардаг бол нэг сум буюу эрхий хуруу шиг том хэмжээтэйг 1,500,000₮-р зардаг.

“Мөөө”, “Сөм” гэх гудамжны нэршилтэй мөс хэмээх химийн гаралтай хар тамхи бий. Метамфетамин буюу сэргээшний төрлийн донтуулагч. Долоо хоногт зарцуулах энергийг 3 хоногт тултал шахаад өгдөг, хоол нойргүй зомби болгодог. Тархины үйл ажиллагааг хурдасгаж улмаар хүйтэн цэвдэг сэтгэлтэн болгодог. Судсаар нь үхэл урсаж эхлэх учир бие хорчийж, судасны төгсгөлүүд тэжээл авахаа больдог. Гадныхны хамгийн л*лрын д тооцох мөс гээч нь манай улсын нууцхан эдийн засгийн хөшүүрэг. Хилээр орж ирээд л үнэ нь 10 үржигддэг. Өндөр эрэлттэй булаацалдаад л дуусдаг. Нэг грамм нь 1.2 сая₮ хүрсэн мөнгө хүүлдэг бизнес юм. ▶▶




2 жил мөсөнд донтсон нэг танилын анх орсон түүх нь “Май энэ лаг гоё юм, амсаад үзээрэй” гэх шинэхэн танилаас эхтэй. Салахдаа өнөөх эр нь хөнгөн инээмсэглээд “Маргааш эргээд холбогдоно биз” гээд явж. Маргааш нь холбогдсон чинь “Алив хүрээд ир, шараа тайл” гэсэн байгаа юм. Манай хүн “Энэ зүгээр гэсэн” гэдэгт нь итгэчихсэн намайг ятгаж нэг үзсэн гэдэг.

Энэ бол хамгийн нийтлэг жишээ. Ихэнх нь зүгээр л мэддэггүй, юу руу хошуу дүрж байгаагаа мэдэлгүй мансуурчихсан сууж байдаг.

ТЭГТЭЛ УЛС МААНЬ ЮУ ХИЙЖ БАЙНА ДАА?

Бамбай буутай нөхөд хаалга үүд балбаж, цонх хагалж баатарлаг царайлж харагддаг. Ардаа түгшүүрний ая наачихсан. Иймэрхүү л пропагандагаар занималддаг, манай Хар Тамхитай Тэмцэх Албаны ‘Фэйж’ хөгжүүлэлтийн мэргэжилтэн.

Саяхан музей нээсэн гэнэ лээ, хүссэн нь орж болно гэсэн. Тэр чигтээ хар тамхины талаар танин мэдэхүйн өрөө юм гэнэ. Маниус нь нэг өглөө сэрээд л “Заа хар тамхиа явж судлая даа!” гэх ёстой юм байх. Амьдралтай ойр, ард иргэддээ хүрэхээр ажилд хөрөнгө гаргахгүй, бас л татвар төлөгчдийн мөнгө цаана нь хямраастай.



Хар тамхи бол манай улсын нууц данс. Өгөөж нь түнэр харанхуйд эргэлддэг. Нийгэм нь ам дамжсан яриа дагаж хэрэглэгч болсоор хохирдог. Эцэст нь мөнгөө ч хүүлүүлдэг, бие ээ ч үнэлдэг. Өнөөх нь ч тэр харанхуйдаа, хэн ч үл мэднэ. Улс нь хар тамхийг төрлөөр нь ангилдаггүй, бөөгнүүлээд шоронгийн шалаар зулчихдаг. Юуг нь ч сургаж заагаагүй жаахан хүүхдүүдээ л аваачаад алуурчидтай нэг өрөөнд оруулчихдаг!

Өнөө үеийн “Ардчилсан” нийгэм прогрессив шийдлүүдийг олж хэрэгжүүлдэг байх ёстой. Ярьдаг байх хэрэгтэй, сэдэв болгож хамтдаа гаргалгааг эрж дадах хэрэгтэй. Хэдий болтол секс, хар тамхи, бие үнэлэлтийг табүү сэдвээр нь дарлаж харлуулах гээд байгаа юм бэ?

ХАМААГҮЙ, БИ ЯРИНА



Хар тамхи гэсэн хар сэдвийн цаана олон мянган түүх, төрөл бүрийн шалтгааны улмаас донтсон, хэлмэгдсэн, мэдээгүйгээсээ болоод сэтгэл зүйгээрээ хохирсон хүмүүс байдаг. Өнөөдөр ард иргэддээ зааж сургаж зөв замд нь залах ёстой бидний толгой-Төр ажлаа хийдэггүй. Ганц хэлдэг юм нь- “Шорон!”

Нэн тэргүүнд бид бүгдэд хар тамхины **хэрэглэгчдийн судалгаа** хэрэгтэй байна. Мөн **ам нээдэг** болмоор байна, үзэл бодлоо нээлттэй хуваалцаж ярьж дадах хэрэгтэй байна. Хэн ч ярихгүй болохоор монголын хөрсөнд ойр шийдлүүдийг хэлэлцэх хүнгүй болоод байна.

Хуулийн хүрээнд **өөрчлөлт** оруулах зайлшгүй **шаардлагатай**. Зарсан, хэрэглэсэн 2 онцын ялгаагүй яллагдаж байгаа нь хар тамхины нийлүүлэлтийг дэмжээд байна. Хар тамхийг төрлөөр нь ангилж яллахгүй байгаа нь хар тамхины хэрэглээг хавтгайруулж хүнд химийн гаралтай хар тамхинд донтогчдын тоог асар хурдтай нэмэгдүүлж байна.

Хар тамхинд донтогчдын сэтгэл зүйг эмчилж, өөрийгөө олоход нь тус болох програм идэвхжүүлж, **тусгай эмнэлэг, тусгай эмчээр** яриулах хэрэгтэй байна. “Би донтчихлоо, туслаач!” гэх **тусламжийн дугаартай** болох цаг нь хэдийн болсон гэж харж байна.

Үргэлжлэл бий...

Хар тамхи хэрэглэсэн хүмүүс өөрсдийгөө хохироосон гэмтэн болохоос бусдын биед хутга мэс хүргэж аллага үйлдсэн ялтан биш юм.

2019 оны 7-р сар



НИЙТЛЭЛ

Б.НАСАНБАЯР

Ph.D /Боловсрол судлал/

EQ БА ИТГЭЛ НАЙДВАР

Хүний амьдралын чанар, ёс зүйн байдал нь сэтгэл хөдлөлөө удирдах чадвараас (Emotional Quotient цаашид EQ гэх) хамаарч төлөвшдөг гэсэн нотолгоо улам бүр батлагдсаар байна. Өнөөдөр манайд “EQ чухал болсон” гэж ярих нь олширч, зарим боловсролын байгууллага энэ чиглэлээр сургалт, үйл ажиллагаа эрхлэх болжээ.

1990 онд анх АНУ-ын Петр Саловей, Жон Мэйер нарын эрдэмтэд өгүүлэл бичиж, сэтгэл судлаач, сэтгүүлч Даниэл Голмэны “Emotional Intelligence” ном 1995 онд хэвлэгдсэнээс хойш бестселлер болж, 40 гаруй орны хэл дээр орчуулагдсанаар EQ-ийн талаар дэлхий нийтээрээ анхаарах суурь тавигдсан байна.

EQ-г хүн өөрийгөө танин мэдэх, идэвхжүүлэх, хянах, эрмэлзэлтэй, тууштай, бусдыг ойлгох, сонсох, хамтран ажиллах ур чадвар гэж тодорхойлжээ. Мөн “хувь хүний чадамж нь мэдлэг, чадвар, ойлголцол, эв дүй, хандлага, туршлага, сэдэл зэргийн харилцан нөлөөлөл бүхий тор шиг олон талст байдлыг агуулдаг” [Klieme, E. 2006] гэж тодорхойлсон байна.

EQ БА ХҮҮХЭД

Өнөөгийн хүүхдүүд бол эдийн засаг, технологийн хөгжлийн санамсаргүй золиос болж байгаад эцэг эхчүүд санаа зовсон ч тэдний “хүн байх-EQ” боловсролыг өөрсдөөсөө холдуулж бусдад даатган, ажлын байран дээрээ илүү их цаг өнгөрөөх нь энгийн үзэгдэл болжээ. Энэ нь хүүхдүүд найз нөхөдтэйгээ тоглож наадах, эцэг эх, ах дүүс, хамаатан садантайгаа хамт амьдрах өдөр тутмын амьдралаар уламжлагдан ирдэг хүн хоорондын харьцаа, хандлагын чадвар буюу EQ хөгжих боломжийг хязгаарласаар байна.

Эцэг эх, хүүхдүүд хоорондын харилцаа удаан хугацаанд хол, хөндий байснаар хүүхэд асар их хэмжээний сэтгэл зүйн хохирол амсдаг. Эцэг эх нь хүүхдийнхээ баяр хөөр, гуниг, тэврүүлэх гэх мэт хэрэгцээг үл тоох, сэтгэл хөдлөл, бусдыг ойлгох чадвараа харуулахгүй байвал хүүхэд нь мэдрэмжээ илэрхийлэхээс зайлсхийж эхэлдэг. Ийм байдал удаан үргэлжилсээр байвал сэтгэл хөдлөл, дотно харилцааны чадвараа үгүйсгэсээр насан туршийн хөгжил, төлөвшилд нь ил, далд шууд нөлөөлдөг.

Харвардын сэтгэл судлаач, олон талт оюун ухааны онолыг боловсруулсан Ховард Гарднер хүүхдүүдийг айлган сүрдүүлэх, эсвэл шагнал урамшуулал өгөхөөс илүү эерэг хандлага, итгэл

найдвар нь дотоод талаас нь идэвхжүүлдэг учир тэднийг “хүн болж” төлөвшихөд хамгийн эрүүл, зөв арга зам гэж тодорхойлжээ. Боловсролын байгууллагууд хүүхэд бүрийн онцлог давуу тал дээр тулгуурлан, чаддаг зүйлээр нь дамжуулан оролцуулах аргаар сургалт үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулах нь тэдний EQ хөгжих, итгэл найдвар төлөвшихөд чухал үүрэгтэй.

Өнөө үед хүн төрөлхтний түүхэнд байгаагүй хугацаагаар хүүхдүүд дэлгэц ширтэн ганцаараа цагийг өнгөрөөх болсон нь урьд үзэгдээгүй бодит байдал. Энэ цаг үеийн технологийн чадвартай хүүхдүүдийг бусад хүмүүсийн мэдрэмж, сэтгэл хөдлөл, хэрэгцээ, зовлон жаргалыг ойлгон мэдрэх чадварт суралцах боломж олгох нь маш том сорилт болж байна.

Хүүхдүүд үнэ цэнээ мэдэрч чадахгүй, сурах хүсэл эрмэлзэлгүй болох үед сургууль дээр болон хаана ч уйдаж зодолдох, ганцаардах, сэтгэл гутралд орох, ууртай, дуулгаваргүй, санаа зовомтгой, түрэмгий хэвийн бус үйлдэл хийхэд хүрдэг. Харин хүүхэд ямар нэгэн сонирхон судалсан, анхаарч санаа тавьдаг зүйлтэй болж, түүнийгээ хийхдээ аз жаргал мэдэрч байгаа үед хамгийн

▶ сайн суралцдаг. Тиймээс 2012-2016 онд Авьяас, Ном, Цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндсэн шалтгаан нь хүүхэд бүр “Би чадна” гэсэн итгэл найдвар, үнэ цэнээ мэдэрч, суралцах чин хүсэл эрмэлзэлтэй болох нь олон асуудлын шийдэл байсан юм. Хүсэл эрмэлзэл дүүрэн шавь нараа

харсан багш өдөр бүр хичээн хөгжиж, эцэг эх, олон нийт хамтран оролцож, бүтээлч боломжийг олон сургуулиуд батлаж байсан ч 2016 оноос боловсролын салбар шалгаж өөрчлөхийн донд автаад, юу чухал гэдгийг анхаарах сөхөө алга.

EQ БА ГЭР БҮЛ

Эцэг эх, үр хүүхдийн хоорондын үл анзаарагдах хэдий ч амьдралын үндэс суурь болсон тоо томшгүй нандин харилцааг анхаарч, хөгжүүлэх нь EQ болон хүн чанар, аюулгүй амьдралын баталгаа болно. Нэг удаагийн болон хэсэг хугацааны сургалтаар EQ буюу сэтгэл хөдлөлөө удирдах чадварыг хөгжүүлэхээс илүүтэй өдөр тутмын гэр бүлийн амьдрал, нийгэм, цэцэрлэг, сургуулийн соёлын орчин, харилцаа хамгийн чухал нөлөөтэй.

АНУ-ын Канзасын их сургуулийн сэтгэл судлаач С.Р.Снайдер дараах судалгааг хийжээ. Коллежийн оюутнуудаас “Хэдийгээр та В үнэлгээ авах зорилго тавьсан боловч чиний эцсийн дүнгийн 30 хувьтай тэнцэх эхний шалгалтын хариу гарахад чи D үнэлгээ авсан байв. Одоо та D үнэлгээ авснаа мэдсэнээс хойш нэг долоо хоног өнгөрсөн байна. Та юу хийх вэ?” гэж асуужээ. Өөртөө итгэх итгэлээс хамаарч ялгаатай хариултауд өгсөн байгаа юм.

- Итгэл найдвар өндөртэй оюутнууд илүү сайн хичээж, эцсийн дүнгээ өсгөх аргын талаар бодно гэж хариулжээ.
- Харин дундаж хэмжээний итгэл найдвартай оюутнууд дүнгээ нэмж болох хэд хэдэн арга замын талаар бодсон боловч тэдгээрийг хэрэгжүүлэх шийдэмгий байдал дутагдаж байв.
- Мэдээж итгэл найдвар багатай оюутнууд аль алинд нь бууж өгөн итгэл найдвараа алдсан байжээ.

С.Р.Снайдер “Итгэл найдвар өндөртэй оюутнууд өөртөө илүү том зорилго тавьдаг учир зорилгодоо хүрэхийн тулд хэрхэн хичээж ажиллахаа мэддэг. Академик амжилтын хувьд адилхан оюуны чадвартай оюутнуудыг хооронд нь харьцуулвал тэднийг ялгаж салгах зүйл нь итгэл найдвар байдаг” хэмээн тайлбарласан байна.

Орчин үеийн эрдэмтдийн олж тогтоосноор итгэл найдвар нь хүний амьдралын бүхий л цагт давуу талыг олгож, амьдралд санаанд оромгүй чухал үүрэг гүйцэтгэдэг ажээ. Мэргэжлийн утгаараа итгэл найдвар нь бүх зүйл сайнаар эргэх болно гэсэн гэрэл гэгээтэй үзэл бодлоос ч илүү зүйл юм. Снайдер үүнийг “өөртөө итгэх нь зорилгоо биелүүлэх хүсэл, урам зориг болоод арга замын аль алиныг өгөх болно” гэж нарийн тодорхойлсон байдаг. EQ өндөртэй, итгэл найдвартай байна гэдэг нь хэцүү сорилттой нүүр тулах үед дааж давшгүй гутранги хандлага, сэтгэл

зовнил, гутралд бууж өгөхгүй гэсэн утгатай юм. Үнэндээ бол итгэл найдвартай хүмүүс зорилгодоо хөтлөгдөн амьдралаа жолоодож, сэтгэлийн хаттай байдаг учраас бусдыг бодвол илүү өөдрөг, сэтгэл зовинох, гутрах нь бага байдаг.

Эцэг эх нь үр хүүхдээ хайрлаж, халамжлахад суралцаж, цаг гаргахгүй бол бидний ирээдүй хаачих нь вэ?

2019 оны 8-р сар
Үргэлжлэл бий



НИЙТЛЭЛ

ТОГТОХЫН ЧУЛУУН

*Доктор (Ph.D.), МУИС-ийн Тогтвортой
Хөгжлийн Хүрээлэнгийн захирал*

НЭГ НУТАГ УСНЫХАНД УЛАМЖЛАЛТ БЭЛЧЭЭР НУТГИЙГ ЦОГЦООР НЬ НИЙТИЙН БУЮУ ХАМТЫН ӨМЧ ХЭЛБЭРЭЭР ЭЗЭМШҮҮЛЬЕ!

Байгалийн баялаг бол төрийн өмч гэсэн Их хурлын, нийтийн өмч гэсэн Ерөнхийлөгчийн ялгаатай саналуудын талаарх хэлэлцүүлэг ид өрнөж байна. Defacto Жаргалсайхан “БАЙГАЛИЙН БАЯЛАГ ЯГ ХЭНИЙ ӨМЧ ВЭ?” 2019 оны 8-р сарын 1-ний тэргүүн өгүүлэлдээ “Үндсэн Хуулиндаа иргэдийн болон нийтийн өмч гэхийн оронд хувийн (хувь хүн, хуулийн этгээдийн), хамтын (тодорхой байршилд оршин суугаа бүлэг хүмүүсийн), улсын (монголын бүх иргэдийн) өмч гэвэл олон улсын жишигт нийцнэ” гэсэн санааг дэвшүүлжээ. Үүнээс тэгш байдал, шударга ёс, үндэсний аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангах төдийгүй нүүдлийн соёл иргэншлээ хадгалан тогтвортой хөгжихөд нэн чухал “хамтын (тодорхой байршилд оршин суугаа бүлэг хүмүүсийн) өмчийн” санааг дэмжиж энэхүү өгүүлийг тэрлэв. Хамтын өмч нь нийтийн өмчийн нэг хэлбэр гэсэн агуулгаар нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг дэмжиж байгаа болно.

Монголчуудын үнэт зүйлсийн нэг бол байгаль орчинтойгоо зохицон хэдэн мянган жил тогтвортой оршин тогтносоор ирсэн нүүдлийн соёл иргэншил. Үүний амин сүнс нь байгальтайгаа өдөр бүр харьцдаг соёл, уламжлалт мэдлэг менежмент, хамтран аж төрөх ёс. Нэг нутаг усныхан олон зуун жил байгальтайгаа зохицож, хамтран тогтвортой амьдарсаар өдийг хүрчээ. Сэргээгдэх байгалийн нөөц баялаг бол монголчуудын тогтвортой аж төрж ирсний үндэс байсаар ирсэн төдийгүй байх ч болно. Монголчуудад байгалийн баялагийг тэгш хүртээх тухай хэлэлцэж буй энэ

түүхэн цаг үед сэргээгдэх байгалийн нөөц баялагийг уламжлалт нэг нутаг усныханд эзэмшүүлэх нь Монгол Улсын тогтвортой хөгжлийн суурь болох юм. Иймээс газар нутаг, газрын дээрх баялаг (ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг)-ийг нэг нутаг усныханд нь хамтын өмч хэлбэрээр цогцоор нь эзэмшүүлэн, нүүдлийн соёл иргэншлийг орчин үеийн технологийн хүчээр сэргээн хөгжүүлэх тухай санааг миний бие монголын бэлчээрийн нийгэм-экологийн тогтолцоог олон жил судалсны үр дүнд тулгуурлан дэвшүүлж байна.

Нэг нутаг усныхан гэсэн уламжлалт ойлголт нь сүүлийн үед ихэвчлэн барууны нөлөөгөөр шинээр бий болсон малчдын бүлэг, бэлчээр ашиглагчдын хэсэг, ойн нөхөрлөл, байгаль хамгаалах нөхөрлөл, хоршоо зэргээс илүү цогц ойлголт. Нэг нутаг усныханд хүмүүс нь ч, мөн нутаг ус нь ч орж байгаагаараа илүү цогц юм. Нэг нутгийнхан, нэг голынхон, нэг усныхан, хот айл, саахалт айл гэх мэт олон ойлголтуудыг нэгтгэн нэг нутаг усныхан гэж нэрийдлээ.

Нэг нутаг усныхан соёлын цогц ландшафтаа олон зуун жил эзэмшин тогтвортой амьдарсаар өдий хүрсэн юм. Соёлын уламжлалт ландшафт нь нэг нутаг усныхны хамтран ашигладаг дөрвөн улирлын бэлчээр, ус, отор, нөөц бэлчээр болон нутгийн иргэдийн шүтлэгтэй газар нутаг бүгдийг хамарна.

Харамсалтай нь соёлын цогц ландшафтыг хэсэгчлэн хуваах үзэгдэл харийн нөлөөнд орсон хэдэн зуун жил үргэлжилсээр ирсэн. Гэвч нэг нутаг усныхан болон соёлын цогц ландшафт нүүдлийн соёл иргэншлийн цөм тул өдий болтол их бага хэмжээгээр хадгалагдсаар ирлээ. Ялангуяа зах хязгаар нутгаар илүү сонгодог байдлаараа байсаар байгааг сэргээх нь үндэсний аюулгүй байдалд бүрэн нийцэх нь ойлгомжтой.

Байгалийн баялаг төрийн өмч байх нь зүйтэй гэсэн санаагаа хамгаалан Занданшатарын ярьсан Хардины (1968)¹ “нийтийн өмчийн эмгэнэл” санааг бүх эрдэмтэд санал нэгтэй дэмждэггүй. Тухайлбал, улс төр судлаач Елиноор Остром² нийтийн буюу хамтын өмчийн ач холбогдлыг нотолсон судалгаагаараа эдийн засгийн салбарт нобелийн шагналыг 2009



- ▶ онд хүртсэн. Тэрээр дэлхийн олон газарт нийтийн буюу хамтын өмчийн засаглал өөрсдийн төдийгүй ирээдүй үеийн хэрэгцээг амжилттай хангаж байгааг харуулсан юм. Остром хамт олноороо нийтийн эзэмшлийг тогтвортой бөгөөд тэгш засаглах 8 зарчмыг олон жилийн судалгаанд тулгуурлан

гаргасан байдаг (1990). Соёлын уламжлалт ландшафт буюу сэргээгдэх байгалийн нөөцийг цогцоор нь нэг нутаг усныханд нь эзэмшүүлэхдээ энэ 8 зарчмыг монголынхоо нөхцөлд тохируулан баримтлах нь зүйтэй.

Хот суурин, дэд бүтэц болон тариалангийн газар нутгийг хөгжүүлэхдээ суурин соёл иргэншилээс суралцах хэрэгтэй нь ойлгомжтой. Харин хөдөө нутгаа хөгжүүлэхдээ уур амьсгал, хуурай газар нутагтаа дасан зохицож олон зуун жил тогтвортой оршсон нүүдлийн соёл иргэншилдээ тулгуурлавал илүү зохистой. Нэг нутаг усныхан бол уламжлалт нийгэм-экологийн тогтолцоо бөгөөд хөдөө нутгийн хөгжлийн цөм болох боломжтой. Гэхдээ экологийн бүс бүрийг өөрийн онцлогт тохируулан хөгжүүлэх хэрэгтэй.

Говь, хээрийн бүсэд нүүдлийн мал аж ахуйгаа аль болох уламжлалт байдлаар хадгалах нь уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицохтой нийцнэ. Нэг нутаг усныханд уламжлалт соёлын ландшафтаа хамтран эзэмших эрхийг нь тодорхой хугацаагаар гэрээгээр өгөх хэрэгтэй. Говь, хээрийн бүс нутагт уур амьсгалын хэлбэлзэл их тул том газар нутагт нүүдэллэж дасан зохицох шаардлага гардаг. Хүн ам сийрэг говь, хээрт газар нутгаа эзэнтэй байлгах нь үндэсний аюулгүй байдлын үүднээс ч зөв зүйтэй бодлого болно.

Хангай нутагт нэг голынхонд уулын амаар нь гэрээгээр эзэмшүүлж болно. Зөвхөн бэлчээрээ эзэмших биш, газар дээрх бүх байгалийн нөөц баялаг болох гол горхи, булаг шанд, ой мод, ан амьтнаа хамтран эзэмшин, хайрлан хамгаалах үүргийг давхар оноогууштай. Уулынхаа аманд цэцэрлэг, бага сургуультай болж, нутгийн амралт, аялал жуулчлалын бааз, малын түүхий эдийн бүтээгдэхүүний жижиг үйлдвэрлэл зэрэг бичил бизнес эрхэлвэл бүр сайн.

Гэрээнд газар нутаг болон байгаль орчноо хамгаалах үүргийг тод томруунаар зааж өгөх нь зүйтэй. Хэрэв уламжлалт газар нутгийнхаа эзэн болж чадахгүй, харийн хүмүүст ашиглуулах эсвэл байгаль орчноо даройтуулах аваас гэрээг цуцлан буцаагаад улсын болгох эрхийг төр өөртөө үлдээнэ. Мөн нийтийн болон улсын тусгай эрх ашгийн үүднээс гэрээг нутгийнхантай зөвшилцөн өөрчлөх эрхийг төрд үлдээхгүй бол гэр хорооллын газрын хувьчлал дэд бүтэц байгуулахад саад болсонтой адил зүйл гарч болзошгүй.

Нэг нутаг усныхны тоонд гадаадад суугаа болон хот газар явсан хүмүүсийн нэр бичээстэй байх нь хөдөө нутгаа хамтран хөгжүүлэх нэг механизм болно. Өөрөөр хэлвэл, хөрөнгө мөнгө, технологи, мэдээллийн урсгалыг хотоос хөдөө рүү чиглүүлэх боломж нээгдэнэ. Нөгөө талаас хотынхонд ч нутгаа хөгжүүлэх, нутагтаа амран эрүүлжих явц улам эрчимжих сайн талтай. Байгаль соёлын аялал жуулчлал, жижиг дунд үйлдвэр хамтран байгуулж, хөдөө нутгаа хөгжүүлснээр Улаанбаатар хотын хүн амын ачаалал буурахад нөлөөлөх бусуу.

Соёлын уламжлалт ландшафтыг нэг нутаг усныханд нь эзэмшүүлэн, нүүдлийн соёл иргэншлийг орчин үеийн мэдээлэл харилцаа, сэргээгдэх эрчим хүч зэрэг технологийн хүчээр сэргээн хөгжүүлэх санаагаа мэргэн уншигчдын оюун бодлыг өдөөн хүргэж байна. Газар, түүн дээрх баялаг, ой, усны нөөц, ан амьтан зэрэг сэргээгдэх байгалийн нөөц баялагийг уламжлалт нэг нутаг усныханд хамтын өмч хэлбэрээр эзэмшүүлэх нь "Байгалийн баялагийг ашиглахдаа тэгш байдал, шударга ёс, үндэсний аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангах зарчим баримтална" гэсэн Үндсэн хуульд шинээр оруулах тулгуур санааг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлэх шинэчлэл төдийгүй Монгол Улсын тогтвортой хөгжлийн суурь болно.

Монголын нэг нутаг усныхан дахин нэгдэн, уламжлалт соёлын ландшафт-байгалийн нөөц, баялагаа эзэмшин, орчин үеийн технологи нэвтрүүлэн, улмаар бие даан тогтвортой хөгжиж мандан бадрах болтугай!

[1] Hardin, G (1968). "The Tragedy of the Commons". Science. 162(3859): 1243–1248.

[2] Ostrom, Elinor (1990). Governing the Commons: The Evolution of Institutions for Collective Action. Cambridge University Press. ISBN 978-0-521-40599-7.